



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# **ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ**

**Дугаар 2019/10**

**Улаанбаатар хот  
2019 он**

## ГАРЧИГ

Агуулга	Хуудасны дугаар
1. Аж үйлдвэр	2
2. Газар тариалан	4
3. Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	6
4. Улаанбаатар хотын гол нэрийн зарим барааны үнэ	7


Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

## 1.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 10 сард урьдчилсан гүйцэтгэлээр 14.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 (13.2%) их наяд төгрөгөөр өслөө. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 10 дугаар сард 1.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх сараас 38.5 (2.5%) тэрбум төгрөгөөр өслөө.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг



Боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2019 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс вакуум цонх, хаалга, ноолууран сүлжмэл эдлэл, банш, бууз, барилгын модон хаалга, цонх зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14.0 хувиас 2.1 дахин өссөн байна. Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт шар айраг, зүсмэл материал, хиаман төрлийн бүтээгдэхүүн, архи, катодын зэс, адууны мах, самнасан ноолуур, малын тэжээл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.7-33.0 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 10 сард урьдчилсан гүйцэтгэлээр 16.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.9 (13.0%) их наяд төгрөгөөр өслөө. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 11.6 их наяд төгрөг буюу 69.0 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ /жил бүрийн эхний 10 сарын байдлаар/

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018		2019*		$\frac{2019^* \text{ I} - \text{X}}{2018 \text{ I} - \text{X}} \%$
		Х	I-X	Х	I-X	
Үхрийн мах	т	1 176.4	4 268.6	311.9	1 187.6	27.8
Хонины мах	т	1 778.4	6 175.4	1 016.0	3 104.4	50.3
Адууны мах	т	4 171.2	12 271.4	1 143.0	10 333.3	84.2
Ямааны мах	т	526.5	4 726.3	105.6	412.5	8.7
Өлөн гэдэс	мян.гогцоо	35.5	512.3	125.2	590.7	115.3
Хиаман бүтээгдэхүүн	т	481.7	4 740.6	527.4	4 641.6	97.9
Шингэн сүү	мян.л	2 689.1	31 505.2	3 758.5	33 036.2	104.9
Тараг	мян.л	1 113.4	11 033.1	1 204.2	11 326.3	102.7
Зайрмаг	мян.ш	6 168.4	91 026.5	6 892.6	95 134.0	104.5
Цэцгий	т	0.5	4.3	0.5	2.9	66.9
Цэцгийн тос	т	15.8	116.2	23.7	170.6	146.8
Өтгөн цэцгий	т	20.5	138.6	23.8	136.9	98.7
Өрөм, зөөхий	т	51.9	281.5	60.1	442.3	157.1
Шар тос	т	18.5	123.0	0.8	129.0	104.9
Бяслаг, аарц	т	23.8	109.1	99.7	371.1	3.4 <sup>1</sup>
Дээд гурил	т	4 551.6	58 058.7	5 008.4	38 749.4	66.7
Нэгдүгээр гурил	т	12 036.7	119 445.3	14 933.4	109 121.6	91.4
Хоёрдугаар гурил	т	1 554.3	15 667.6	1 488.0	12 720.1	81.2
Малын тэжээл	т	9 094.3	85 581.4	7 120.6	57 332.1	67.0
Талх	т	2 542.1	22 106.8	2 482.0	22 965.9	103.9
Нарийн боов	т	1 756.2	15 949.3	1 895.5	17 989.8	112.8
Бялуу	т	175.5	1 551.7	218.8	1 863.9	120.1
Чихэр	т	3.2	46.4	1.9	40.3	86.8
Жигнэмэг	т	29.6	258.6	164.2	1 005.5	3.9 <sup>1</sup>
Гоймон	т	561.8	6 165.1	778.9	7 276.8	118.0
Пүнтүүз	т	5.3	33.8	4.3	39.9	118.0
Бууз, банш	т	386.2	2 474.4	463.5	4 217.9	170.5
Савласан ногоон цай	кг	7 695.4	61 424.3	17 770.3	92 125.5	150.0
Шарсан төмс	т	134.7	968.6	178.2	1 295.0	133.7
Спирт	мян.л	1 010.2	8 721.8	744.6	8 637.9	99.0
Архи	мян.л	2 295.4	24 173.0	1 847.2	22 215.6	91.9
Дарс	мян.л	7.0	65.3	15.8	189.3	2.9 <sup>1</sup>
Шар айраг	мян.л	7 789.0	77 301.5	8 094.4	76 759.6	99.3
Цэвэр ус	мян.л	5 311.1	58 928.1	8 245.7	86 750.1	147.2
Амтат ус, ундаа	мян.л	10 993.6	140 960.3	15 325.2	144 840.2	102.8
Жүүс	мян.л	5 286.4	56 167.8	5 786.1	54 350.7	96.8
Тамхи	мян.блок	709.0	3 600.8	638.7	3 463.1	96.2
Хивс	мян.м <sup>2</sup>	57.0	442.6	47.9	390.7	88.3
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	161.1	1 129.7	154.3	1 462.0	129.4
Самнасан ноолуур	т	107.6	1 036.6	60.0	700.2	67.6
Эсгий	мян.м	11.5	101.3	23.5	119.2	117.6
Тэмээний ноосон хөнжил	мян.м	0.8	8.6	0.5	5.9	68.6
Эсгий гутал	мян.хос	0.0	0.1	0.1	0.4	4.8 <sup>1</sup>

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018		2019*		$\frac{2019^* \text{ I} - \text{X}}{2018 \text{ I} - \text{X}} \%$
		X	I-X	X	I-X	
Нэхий дээл	ш	1 118.0	6 942.0	1 321.0	10 348.0	149.1
Савхин гутал, ботинк	мян.хос	7.1	40.5	4.3	32.5	80.2
Барилгын модон хаалга, цонх	м <sup>2</sup>	17.1	226.1	3.0	463.8	2.1 <sup>1</sup>
Вакуум цонх, хаалга	м <sup>2</sup>	6 368.7	31 513.1	5 874.9	35 928.0	114.0
Зүсмэл материал	м <sup>3</sup>	760.8	13 017.4	1 090.3	12 868.9	98.9
Төмөр замын дэр мод	мян.м <sup>3</sup>	1.3	12.8	1.0	11.8	92.2
Дэвтэр	мян.ш	778.3	18 661.4	101.1	14 819.3	79.4
Ариун цэврийн цаас	мян.ш	434.2	3 002.0	290.0	3 286.4	109.5
Сонин	сая х.д.х	1.6	18.9	1.6	14.5	76.9
Ном	сая х.д.х	12.1	87.3	29.6	136.0	155.8
Хэвлэмэл хуванцар картууд	мян.ш	29.0	284.8	29.0	403.8	141.8
Шахмал эм	мян.боодол	1 273.4	10 583.7	385.8	7 176.3	67.8
Шингэн эм	т	381.6	3 348.6	232.2	1 951.4	58.3
Гоо сайхны тос	мян.ш	85.6	1 022.5	103.7	1 486.6	145.4
Цемент	мян.т	128.3	892.2	147.0	1 007.1	112.9
Шохой	мян.т	4.7	47.7	8.2	66.6	139.7
Төмөр бетон эдлэл	мян.м <sup>3</sup>	6.1	38.6	10.2	47.1	122.2
Бетон дэр	мян.ш	-	20.7	7.2	22.2	107.6
Катодын зэс, 99%	т	1 255.0	11 707.4	933.7	9 914.0	84.7
Металл бэлдэц	т	2 435.1	23 291.9	2 126.0	23 875.3	102.5
Металл цувимал	т	3 839.0	26 126.5	0.0	23 586.7	90.3
Ган төмөр хийц	мян.т	0.7	5.8	1.0	7.6	130.7
Цахилгааны утас	т	11.4	77.8	13.4	76.5	98.3

Тайлбар: \* Урьдчилсан гүйцэтгэл  
<sup>1</sup> Дахин их

## 2. ГАЗАР ТАРИАЛАН




Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар 397.2 мянган тонн үр тариа, 189.2 мянган тонн төмс, 91.1 мянган тонн хүнсний ногоо хурааж, 1.1 сая тонн өвс хадлан, 39.6 мянган тонн гар тэжээл, 5.3 мянган тонн дарш бэлтгэсэн байна. Өмнөх оны мөн үеэс хураасан төмс 22.6 (13.5%) мянган тонноор, бэлтгэсэн өвс хадлан 16.8 (1.5%) мянган тонноор, бэлтгэсэн гар тэжээл 3.1 (8.4%) мянган тонноор, бэлтгэсэн дарш 0.8 (16.7%) мянган тонноор өсөж, харин хураасан үр тариа 18.9 (4.5%) мянган тонноор, хүнсний ногоо 3.9 (4.2%) мянган тонноор тус тус буурчээ. Дорнод, Хөвсгөл, Увс, Булган, Төв, Сэлэнгэ аймгууд нийт хураасан үр тарианы 87.9 хувийг, Дархан-

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**


Уул, Ховд, Сэлэнгэ, Төв аймгууд нийт хураасан төмсний 81.6 хувийг, Улаанбаатар хот, Ховд, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгууд нийт хүнсний ногооны ургацын 76.7 хувийг тус тус эзэлж байна. Хураасан үр тариа Баян-Өлгий, Хэнтий, Говь-Алтай, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Увс, Дорнод, Төв аймгуудад өмнөх оны мөн үеэс 5.2 тонноос 11.4 мянган тонноор буюу 1.4-90.1 хувиар өсөж, бусад аймагт 2.1 тонноос 38.1 мянган тонноор буюу 4.9-66.8 хувиар тус тус буурчээ. Хураасан төмс Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Хэнтий, Ховд, Орхон, Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ, Баян-Өлгий, Төв аймгуудад 1.5 тонноос 22.7 мянган тонноор буюу 1.4-49.3 хувиар өсөж, бусад аймагт 7.2 тонноос 0.6 мянган тонноор буюу 1.3-53.0 хувиар тус тус буурсан байна. Хураасан хүнсний ногоо Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Улаанбаатар хот, Баян-Өлгий, Ховд, Завхан, Өвөрхангай, Орхон, Архангай, Төв аймгуудад 14.7 тонноос 2.0 мянган тонн буюу 1.2 хувиас 2.5 дахин өсөж, бусад аймагт 35.8 тонноос 3.3 мянган тонноор буюу 5.3-46.3 хувиар буурчээ. Бэлтгэсэн хадлан Орхон, Дорноговь, Дундговь, Ховд, Говь-Алтай, Архангай, Завхан, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Төв, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл аймгуудад 9.5-26.0 мянган тонноор буюу 0.1 хувиас 2.8 дахин өсөж, харин бусад 0.2-16.9 мянган тонноор буюу 0.5-66.6 хувиар буурчээ.

*Хураасан ургац, бэлтгэсэн өвс хадлан, гар тэжээл, жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний байдлаар, мянган тонн*



### 3.ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 10 дугаар сард соёолон үрээ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 1.0 сая төгрөг, Баянхонгор аймагт хамгийн бага буюу 728.6 мянган төгрөг, хязаалан шар Төв аймагт хамгийн их буюу 1.3 сая төгрөг, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 766.7 мянган төгрөг, ат Өмнөговь аймагт хамгийн их буюу 1.2 сая төгрөг, Булган аймагт хамгийн бага буюу 800.0 мянган төгрөгийн үнэтэй байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Дархан-Уул аймагт хамгийн их буюу 203.8 мянган төгрөг, Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 116.7 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Дархан-Уул аймагт хамгийн их буюу 143.8 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 92.5 мянган төгрөг байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 10 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай ширний дундаж үнэ Улаанбаатар хотод хамгийн их буюу 11.7 мянган төгрөг, Ховд, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 2.0 мянган төгрөг, бусад аймагт 3.0-10.0 мянган төгрөг байна. Адууны ширний дундаж үнэ Дорноговь, Хэнтий аймагт хамгийн их буюу 9.0 мянган төгрөг, Увс, Дорнод аймагт хамгийн бага буюу 3.0 мянган төгрөг, бусад аймагт 5.0-8.0 мянган төгрөг байна. Хонины ноостой нэхийний дундаж үнэ Дундговь, Хэнтий аймагт хамгийн их буюу 3.0 мянган төгрөг, Завхан аймагт хамгийн бага буюу 1.0 мянган төгрөг, бусад аймагт 1.5-2.8 мянган төгрөг байна. Ямааны цагаан ноолуурын нэг килограммын дундаж үнэ Хөвсгөл аймагт хамгийн их буюу 65.0 мянган төгрөг, Булган, Дорнод аймагт хамгийн бага буюу 40.0 мянган төгрөг, бусад аймагт 45.0- 60.0 мянган төгрөг байна.



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2019 оны 10 дугаар сард 1 тонн үрийн буудайн дундаж үнэ Орхон аймагт хамгийн их буюу 830.0 мянган төгрөг, Төв аймагт хамгийн бага буюу 632.5 мянган төгрөг, 1 тонн таваарын буудайн дундаж үнэ Төв аймагт хамгийн их буюу 565.0 мянган төгрөг, Увс аймагт хамгийн бага буюу 360.0 мянган төгрөг байна. 1 тонн овъёсны дундаж үнэ Архангай, Орхон аймагт хамгийн их буюу 700.0 мянган төгрөг, Төв аймагт хамгийн бага буюу 495.0 мянган төгрөг, 1 тонн ногоон тэжээлийн дундаж үнэ Хөвсгөл аймагт хамгийн их буюу 440.0 мянган төгрөг, Архангай аймагт хамгийн бага буюу 200.0 мянган төгрөг байна.

Боодолтой өвсний (20кг) дундаж үнэ Баянхонгор аймагт хамгийн их буюу 11.0 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 3.7 мянган төгрөг, бусад аймагт 4.0-10.5 мянган төгрөг, 1 тонн задгай өвсний дундаж үнэ Завхан аймагт хамгийн их буюу 260.0 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг, бусад аймагт 101.0-210.0 мянган төгрөг байна.

#### 4.УЛААНБААТАР ХОТЫН ГОЛ НЭРИЙН ЗАРИМ БАРААНЫ ҮНЭ

№	Барааны нэр		2019 он			2019.XI - 13	2019.XI - 13
			10 сарын дундаж үнэ	11 сарын 6-ны үнэ	11 сарын 13-ны үнэ	% 2019.X сар	% 2019.XI - 06
1	"Алтан тариа" гурил	дээдийн дээд, савласан, кг	1710	1 710	1 710	100.0	100.0
		дээд, савласан, кг	1450	1 450	1 446	99.7	99.7
		1 зэрэг, савласан, кг	1100	1 090	1 090	99.1	100.0
		2-р зэрэг, савласан, кг	886	886	886	100.0	100.0
2	Талх	"Атар", 600 гр	1303	1 303	1 303	100.0	100.0
		"Зууван чех", 600 гр	1468	1 468	1 468	100.0	100.0
		Хар талх, 300 гр	982	982	982	100.0	100.0
3		Цагаан будаа, кг	3539	3 560	3 675	103.8	103.2
4		Хонины мах, ястай, кг	9084	8 334	7 694	84.7	92.3
5		Үхрийн мах, ястай, кг	10943	10 198	10 275	93.9	100.8
6		Үхрийн мах, цул, кг	14038	13 377	13 236	94.3	99.0
7		Адууны мах, ястай, кг	8488	8 365	8 365	98.5	100.0
8		Ямааны мах, ястай, кг	7687	7 246	6 000	78.1	82.8
9	Сүү	задгай, л	1405	1 449	1 249	88.9	86.2
		"Элекстер", 0.5 л	1106	1 106	1 106	100.0	100.0
		"Шинэ Сүү", л	2651	2 651	2 655	100.2	100.2
10		Тараг, савласан, 900 гр, "Цөцгийтэй"	2483	2 483	2 500	100.7	100.7
11		Цөцгийн тос, 250 гр	3860	3 860	3 860	100.0	100.0
12		Ургамлын тос, л	3559	3 559	3 559	100.0	100.0
13		Элсэн чихэр, кг	2727	2 727	2 796	102.5	102.5
14		Ногоон цай, савласан, 90 г	1531	1 531	1 531	100.0	100.0
15		Өндөг, ш	333	333	333	100.0	100.0
16		Алим, "Фүжи" сортын, кг	4161	4 130	4 130	99.2	100.0
17		Төмс, дотоод, кг	866	796	790	91.2	99.1
18		Лууван, дотоод, кг	1410	1 128	1 097	77.8	97.3
19		Байцаа, импортын, кг	1527	1 289	1 231	80.6	95.5
20		Хүрэн манжин, дотоод	2648	2 584	1 506	56.9	58.3
21		Сонгино, бөөрөнхий, импортын, кг	1281	1 269	1 234	96.3	97.2
22	Шатахуун	Аи-80 автобензин, л	1673	1673	1673	100.0	100.0
		Аи-92 автобензин, л	1826	1828	1828	100.1	100.0
		Дизелийн түлш, л	2351	2354	2354	100.1	100.0
<b>ДҮН</b>						<b>93.6</b>	<b>97.2</b>

2019 оны 11-р сарын 13-ны байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 6.0 хувь, өмнөх 7 хоногоос 2.4 хувиар буурсан байна.